



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/189-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: А.Гэрэлмаа Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3.Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4. Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асудитын асуудал	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт.....	19
4.1 Залруулсан алдаа	Error! Bookmark not defined.
4.2 Төлбөрийн акт	Error! Bookmark not defined.
4.3 Албан шаардлага	Error! Bookmark not defined.
4.3 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЭА	Сэлэнгэ аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: selenge@audit.gov.mn

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН СҮХБААТАР
СУМЫН 5 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ С.СЭЛЭНГЭ ТАНАА**

2022.02.25 № СЭА-2022/189-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	39,826,634.60	67,513,359.08
33	АВЛАГА	1,098,048.60	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,098,048.60	-
35	БАРАА МАТЕРИАЛ	38,728,586.00	67,513,359.08
35100	Түүхий эд материал	-	144,000.00
35130	Эм боох материал	-	144,000.00
35400	Хангамжийн материал	38,728,586.00	67,369,359.08
35410	Бичиг хэргийн материал	440,300.00	465,500.00
35420	Аж ахуйн материал	826,550.00	547,604.54
35450	Барилгын засварын материал	363,170.00	285,000.00
35460	Хүнсний материал	280,656.00	621,775.00
35470	Бусад хангамжийн материал	36,817,910.00	65,449,479.54
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,098,194,032.34	2,067,313,095.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,098,194,032.34	2,067,313,095.30
39200	Биет хөрөнгө	2,097,816,549.02	2,067,013,712.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,069,299,344.00	2,069,299,344.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(57,544,218.32)	(92,032,540.64)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	43,644,852.00	59,411,052.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(11,300,790.88)	(20,348,287.96)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,668,340.00	55,668,340.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,127,224.38)	(24,499,292.30)
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,611,496.00	26,611,496.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,435,249.40)	(7,096,399.04)
39300	Биет бус хөрөнгө	377,483.32	299,383.24
39301	Програм хангамж	390,500.00	390,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(13,016.68)	(91,116.76)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,138,020,666.94	2,134,826,454.38
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,138,020,666.94	2,134,826,454.38
51	Засгийн газрын хувь оролцоо	2,138,020,666.94	2,134,826,454.38
51200	Хуримтлагдсан үр дүн	2,138,020,666.94	2,134,826,454.38
51210	Өмнөх үеийн үр дүн	2,174,329,744.25	2,138,020,666.94
51220	Тайлант үеийн үр дүн	(36,309,077.31)	(3,194,212.56)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,138,020,666.94	2,134,826,454.38

2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	405,565,955.00	463,291,455.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,636,042.00	2,868,155.08
120	Нийтлэг татварын бус орлого	12,636,042.00	2,868,155.08
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	7,598,452.00	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	5,037,590.00	2,868,155.08
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	392,929,913.00	460,423,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	350,196,500.00	418,885,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	350,196,500.00	418,885,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,015,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,015,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,733,413.00	40,522,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,733,413.00	40,522,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	441,875,032.31	466,485,667.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	441,875,032.31	466,485,667.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	412,246,724.87	403,581,347.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	230,524,544.92	245,515,383.63
210101	Үндсэн цалин	154,308,823.05	182,499,800.76
210102	Нэмэгдэл	57,131,186.77	43,557,711.25
210104	Урамшуулал	19,084,535.10	19,457,871.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,477,078.13	32,892,765.96
210201	Тэтгэврийн даатгал	20,341,444.70	23,257,142.23
210202	Тэтгэмжийн даатгал	2,325,493.77	2,533,379.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,789,833.01	1,986,383.35
210204	Ажилгүйдлийн даатгал	421,294.62	450,372.05
210205	Эрүүл мэндийн даатгал	4,599,012.03	4,665,489.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,633,413.00	40,522,900.00
210301	Гэрэл, цахилгаан	2,533,520.00	1,100,542.00
210302	Түлш, халаалт	31,117,832.00	28,642,500.00
210303	Цэвэр, бохир ус	5,982,061.00	10,779,858.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,259,885.00	7,411,981.00
210401	Бичиг хэрэг	3,362,850.00	2,277,200.00
210402	Тээвэр, шатахуун	185,000.00	120,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	133,900.00	1,278,500.00
210404	Ном, хэвлэл	90,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,156,000.00	424,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,857,645.00	3,311,531.00
210408	Бараа материал акалсны зардал	23,474,490.00	-
2105	Нормативт зардал	21,435,063.40	16,063,359.60

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	189,200.00	1,068,200.00
210502	Хоол, хүнс	20,795,863.40	14,995,159.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	450,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,175,130.00	2,403,820.00
210604	Урсгал засвар	3,175,130.00	2,403,820.00
2107	Томилолт, зочны зардал	128,000.00	-
210702	Дотоод албан томилолт	128,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,062,800.00	2,624,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	606,800.00	1,877,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	132,000.00	99,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,550,810.42	56,147,137.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,494,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	214,200.00	500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,842,610.42	55,647,137.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,628,307.44	62,904,320.41
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,628,307.44	62,904,320.41
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,628,307.44	62,904,320.41
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(36,309,077.31)	(3,194,212.56)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(36,309,077.31)	(3,194,212.56)
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	-	-
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	-	-

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	392,929,913.00	460,423,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	392,929,913.00	460,423,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	350,196,500.00	418,885,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	350,196,500.00	418,885,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,015,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,015,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,733,413.00	40,522,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,733,413.00	40,522,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	387,019,413.00	435,657,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	387,019,413.00	435,657,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	357,391,105.56	372,752,779.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	230,157,659.92	245,515,383.63
210101	Үндсэн цалин	153,941,938.05	182,499,800.76
210102	Нэмэгдэл	57,131,186.77	43,557,711.25
210104	Урамшуулал	19,084,535.10	19,457,871.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,656,956.64	32,892,765.96
210201	Тэтгэврийн даатгал	20,288,927.21	23,257,142.23
210202	Тэтгэмжийн даатгал	2,194,750.77	2,533,379.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,088,285.22	1,986,383.35
210204	Ажилгүйдлийн даатгал	459,486.41	450,372.05
210205	Эрүүл мэндийн даатгал	4,625,507.03	4,665,489.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,633,413.00	40,522,900.00
210301	Гэрэл, цахилгаан	2,533,520.00	1,100,542.00
210302	Түлш, халаалт	31,117,832.00	28,642,500.00
210303	Цэвэр, бохир ус	5,982,061.00	10,779,858.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,661,055.00	6,092,800.00
210401	Бичиг хэрэг	500,000.00	934,500.00
210402	Тээвэр, шатахуун	185,000.00	120,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	90,100.00	1,278,500.00
210404	Ном, хэвлэл	90,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,156,000.00	688,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,639,955.00	3,071,050.00
2105	Нормативт зардал	26,342,121.00	30,138,230.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	189,200.00	1,000,000.00
210502	Хоол, хүнс	18,770,121.00	14,238,230.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,382,800.00	14,900,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,439,000.00	2,658,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	533,700.00
210604	Урсгал засвар	12,439,000.00	2,124,500.00
2107	Томилот, зочны зардал	128,000.00	-

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	128,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,970,900.00	8,280,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,787,400.00	7,632,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	859,500.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,402,000.00	6,652,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,782,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,620,000.00	6,652,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,628,307.44	62,904,320.41
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,628,307.44	62,904,320.41
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,628,307.44	62,904,320.41
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,910,500.00	24,766,200.00
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,910,500.00	24,766,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,910,500.00	24,766,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,910,500.00	24,766,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,910,500.00	24,766,200.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(5,910,500.00)	(24,766,200.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,174,329,744.25	2,174,329,744.25
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,174,329,744.25	2,174,329,744.25
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(36,309,077.31)	(36,309,077.31)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,138,020,666.94	2,138,020,666.94
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	2,138,020,666.94	2,138,020,666.94
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,138,020,666.94	2,138,020,666.94
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(3,194,212.56)	(3,194,212.56)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	2,134,826,454.38	2,134,826,454.38

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	459,408,300.00	396,503,979.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	459,408,300.00	396,503,979.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	459,408,300.00	396,503,979.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,050,000.00	245,515,383.63
210101	Үндсэн цалин	194,660,000.00	182,499,800.76
210102	Нэмэгдэл	46,100,000.00	43,557,711.25
210104	Урамшуулал	25,290,000.00	19,457,871.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,314,600.00	32,892,765.96
210201	Тэтгэврийн даатгал	25,168,600.00	23,257,142.23
210202	Тэтгэмжийн даатгал	2,786,500.00	2,533,379.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,229,200.00	1,986,383.35
210204	Ажилгүйдлийн даатгал	557,300.00	450,372.05
210205	Эрүүл мэндийн даатгал	5,573,000.00	4,665,489.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,522,900.00	40,522,900.00
210301	Гэрэл, цахилгаан	1,470,000.00	1,100,542.00
210302	Түлш, халаалт	28,327,300.00	28,642,500.00
210303	Цэвэр, бохир ус	10,725,600.00	10,779,858.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,877,800.00	5,877,800.00
210401	Бичиг хэрэг	934,500.00	934,500.00
210402	Тээвэр, шатахуун	120,000.00	120,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,266,400.00	1,278,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	476,000.00	473,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,080,900.00	3,071,050.00
2105	Нормативт зардал	68,673,700.00	30,138,230.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,000,000.00	1,000,000.00
210502	Хоол, хүнс	52,773,700.00	14,238,230.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,900,000.00	14,900,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,424,500.00	27,424,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,300,000.00	16,299,900.00
210602	Тавилга	9,000,000.00	9,000,000.00
210604	Урсгал засвар	2,124,500.00	2,124,500.00
2107	Томилолт, зочны зардал	80,000.00	-
210702	Дотоод албан томилолт	80,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,812,300.00	7,480,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,840,300.00	6,832,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	972,000.00	648,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,652,500.00	6,652,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,652,500.00	6,652,500.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	459,408,300.00	396,503,979.59
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	418,885,400.00	355,981,079.59

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

310001	Улсын төсвөөс санхүүжих	-	-
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	418,885,400.00	355,981,079.59
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	40,522,900.00	40,522,900.00
320001	Орон нутгийн төсвөөс	40,522,900.00	40,522,900.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	236	236
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25	25
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8
620003	Үйлчлэх ажилтан	16	16
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	185	185
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	185	185
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	185	185
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	25
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	25	25

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,015,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,015,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,015,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		215,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		215,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		800,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		800,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,015,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,015,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,015,000.00

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэгийн /цаашид Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэг гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу Мэдээлэл аудит ХХК-ийн Сэлэнгэ салбарын аудитор А.Гэрэлмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-ийн Сэлэнгэ салбарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэг нь *"Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад багш, ажилтан бүр хамтран хүүхдийн сурч хөгжих таатай орчныг бүрдүүлэх, багш эцэг эх хүүхдийн сурч хөгжихөд харилцан дэмжлэг үзүүлж, хамтын ажиллагааны явцад сургалтын чанарыг сайжруулах"* гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх насны хүүхдэд боловсрол олгох

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах босго үнийг “Босго үнэ шинэчлэн батлах тухай” Монгол улсын засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор шинэчлэн хийгдсэн гэх мэт Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэгийн 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж санхүүгийн үйл ажиллагааг үнэн зөв илэрхийлэн зориулалтын дагуу зарцуулсан, бүртгэл хөтлөлт сайн, харин шилэн дансны мэдээлэл байршуулалт хангалтгүй гэж үнэлэгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 441,875.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,418.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 3,093.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,194.2 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,098.0	-	(1,098.0)
Татаас санхүүжилтийн авлага			-
Байгууллагаас авах авлага			-
Урьдчилж төлсөн зардал			-
Бараа материал	38,728.6	67,513.4	28,784.8
Үндсэн хөрөнгө	2,098,194.0	2,067,313.1	(30,880.9)
Нийт хөрөнгө	2,138,020.7	2,134,826.5	(3,194.2)
Өр төлбөр			-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,138,020.7	2,134,826.5	(3,194.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,138,020.7	2,134,826.5	(3,194.2)

Бараа материалын дансны үлдэгдэл 28,784.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн хүнсний материал, аж ахуйн материал, хангамжийн материалын зарцуулагдаагүй үлдэгдлээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 24,766.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр нийт 24,766.2 мянган төгрөгийн принтер, хүүхдийн ор, тоос сорогч, телевизор, ус цэвэршүүлэгч, угаалгын машин зэргийг худалдан авч данс бүртгэлд тусгаснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,134,826.5 мянган төгрөг болж 3,194.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 463,291.5 мянган төгрөг болж өмнөх оноос 57,725.5 мянган төгрөгөөр буюу 14.2 хувиар өссөн байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 466,485.7 мянган төгрөг болж өмнөх оноос 24,610.6 мянган төгрөгөөр буюу 5.6 хувиар өссөн. Энэ нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор багш, ажиллагсдыг вакцинжуулалт, Шаамар-6 постонд ажиллуулах зэргээр илүү цагийн нэмэгдэл хөлс олгосноос цалин, нийгмийн даатгалын зардал өссөн болон цэвэр бохир усны үнэд өөрчлөлт орсон зэргээс голлон нөлөөлсөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 485,515.9 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 26,107.6 мянган төгрөгөөр бууруулан 459,408.3 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр **459,408.3** мянган төгрөгийн төсөв баталснаас 418,885.4 мянган төгрөгийг улсын төсвөөс */тусгай зориулалтын шилжүүлгээр/*, 40,522.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 418,885.4 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 40,522.9 мянган төгрөгийн санхүүжилт нийт 459,408.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 396,504.0 мянган төгрөгийг зарцуулан, 62,904.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **396,504.0** мянган төгрөг буюу 86.3 хувьтай тайлагнагдсан нь цалингийн зардал 20,534.6 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын зардал 3,421.8 мянган төгрөгөөр, хоол 38,535.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 412.9 мянган төгрөгөөр зэрэг нийт 62,904.3 мянган төгрөгийн зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд Боловсрол соёл урлагийн газраас */Ковид-19/* цар тахлаас урьдчилан сэргийлэх ариутгалын ажилд дэмжлэг үзүүлж 215.0 мянган төгрөгийн, Онцгой байдлын газраас 800.0 мянган төгрөгийн, нийт 1,015.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3 дахь *“Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур*

чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.” гэсэн заалт болон Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 тушаалын 10 дахь “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10%, сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15%, аймаг, нийслэлийн түвшинд амжилт гаргасан 20%, улс, бүс, олон улсын түвшинд амжилт гаргасан 25%” гэж заасан боловч цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш, туслах багшийн ажлын үр дүнг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг сард 10-25 хувиар тооцож олгож байна. Цаашид ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн олгож байх нь зүйтэй юм.

3.7.2 БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын нэгдүгээр хавсралт “Короновируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансанд нийт мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэгийн тайлант оны үйл ажиллагаанд **459,408.3** мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр **396,504.0** мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 13.7 хувиар хэмнэж Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг хэрэгжүүлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн 1200.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 2 албан шаардлага өгөгдсөнийг бүрэн биелүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 24,766.2 мянган төгрөгийн шинээр нэмэгдэж, бүртгэгдсэн хөрөнгүүдийг биетээр тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар анхааран үзэх нь зүйтэй юм.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 80,142.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч 1 зөвлөмж өглөө.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. *Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал*

1.1 *Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд*

1.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 80,142.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэг	1	80,142.3							1	80,142.3